



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/154

Цагаан-Уул сум

┌ Хүлээн авах комисс томилох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх сумын төвийн зам засварын ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: Д.Мөнхбат (Татварын улсын байцаагч)

Гишүүд: А.Энхбаяр (Хэсгийн төлөөлөгч)

Г.Ууганбаяр (Жаргалант багийн Засаг дарга)

А.Хишигбаяр (Төрийн сангийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Н.Пүрэвжаргал (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу дээрх ажлыг хүлээн авч, тэмдэглэл үйлдэж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГОНЧИГНЯМ